

# АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

## 1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг баримтлан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, худалдан авах ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих, төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, эрсдэлийн удирдлагаар хангах, дүгнэлт зөвлөмж боловсруулж үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллав.

Тус газар нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай 30 дугаар тогтоол, АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/50 дугаар тушаалаар 6 албан хаагчийн бүтэц орон тоотойгоор батлагдсан ХШҮДАГ-ын даргаар Б.Өнөмөнх, ахлах шинжээч И.Баттуяа, Д.Батнайрамдал, шинжээч Ц.Тэмүүжин, ахлах мэргэжилтэн Б.Баттуул, мэргэжилтэн Т.Нарантүвшин нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- ❖ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн “Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай” А/61 дүгээр тушаалын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын хамтарсан-6, гүйцэтгэлийн-2, нийт 8 дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна.
- ❖ “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тус газрын хэрэгжүүлэх нийт 3 зорилтын 40 арга хэмжээг баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд, батлагдсан төсөвт багтаан зохион байгуулан ажилласан.

## 2. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын 2024 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу “Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох журам”-ын хэрэгжилтэд дотоод аудит хийж,

үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах зорилтын хүрээнд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик тээврийн сургуулийн 2017-2024 он, Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн 2018-2024 оны үйл ажиллагааг дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитаар зэрэг олгох сургалтын хөтөлбөр, шаардлагын дагуу зэрэг горилогчдын бүрдүүлсэн материал, шалгалтын материал, зохион байгуулалтын зардал, мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгосон байдалд дотоод аудитыг гүйцэтгэж, дүгнэлт зөвлөмжийг гаргаж, шалгалтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулав.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Газрын тосны салбарт Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардал баталгаажуулалт, газрын тосны экспорт, борлуулалтын тооцоо, хуваарилалтын баталгаажуулалтад хийсэн аудитаас өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт, өмнөх аудитаас өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг хэрэгжүүлэх зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны А/18 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хяналт шалгалтыг хийсэн. Ажлын хэсгээс гарсан зөвлөмж, дүгнэлтийг удирдлагуудад танилцуулж, 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 03/860 дугаар албан бичгээр зөрчил арилгах төлөвлөгөөг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлж ажилласан. Төлөвлөгөөний дагуу АМГТГ-аас 2024 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 3/2957 дугаар албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газрын аудитын шалгалтаар өгсөн акт, албан шаардлагын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газраас шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч төрийн байгууллагуудын ажлын уялдаагүй байдал, асуудал шийдвэрлэгдэхгүй удаашрах, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх хугацаа бага байгаагаас хэрэгжилтийг хангахад гэрээлэгчид болон төрийн захиргааны байгууллагад хүндрэл учирсан байна.

Газрын тосны тухай, Нийгмийн даатгалын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хууль болон холбогдох журамд нийцээгүй Бүтээгдэхүүн хуваах гэрээний заалтыг шинэчлэх асуудал нь яриа хэлэлцээрийн замаар шат дараатайгаар урт хугацаанд шийдэгдэх асуудал бөгөөд Засгийн газрын түвшинд асуудлыг хянан үзэж байна.

3. Уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийж, дотоод аудитын тайланг яамны удирдлагуудад танилцуулагдсан болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах ажиллагаа 2023 оны жилийн эцсийн байдлаар 3,762,424.20 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төрлийн худалдан авалтад 3,738,161.35 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 24,262.8 мянган төгрөгийг хэмнэж зарцуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын хүрээнд дотоод аудитыг хийж гүйцэтгэв.

4. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга ажлын албаны 2023-2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд дотоод аудит хийж, шалгалтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулан төслийн бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэн.
5. Ашигт малтмал, газрын тосны газрын 2023-2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд дотоод аудит хийж, шалгалтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулсан.
6. Үндэсний геологийн албаны 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд дотоод аудит хийж, шалгалтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулсан.
7. “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨААТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд дотоод аудит хийж, шалгалтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулсан.
8. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудитыг хийж, шалгалтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулсан.

Үндэсний аудитын газраас 2023 онд сайдын багцад хийсэн санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын хүрээнд гарсан зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллахаар ажлын хэсэг байгуулах, эрчимжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хянах, зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж хариу хүргүүлэх ажлуудыг гүйцэтгэсэн. Жилийн эцсийн байдлаар Үндэсний аудитын газарт 10, сайдын багцын харьяа байгууллагууд, яамны дотоод нэгжүүдэд нийт 11 албан бичгийг хүргүүлсэн байна.

### 3.БУСАД ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хөгжлийн бодлого, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хуулийн хугацаанд буюу сар, улирал, жилээр гүйцэтгэлийг хянаж, Засгийн газрын [uneelgee.gov.mn](http://uneelgee.gov.mn), Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны яамны [mmhi.gov.mn](http://mmhi.gov.mn) цахим хуудсанд 12 төрлийн үнэлгээний тайланг байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.

Байгууллага, иргэдээс албан бичгээр ирсэн нийт 79 албан бичиг, өргөдөл, хүсэлттэй танилцан судалсны дагуу жилийн эцсийн байдлаар хугацаатай, хариутай 72 албан бичигт хариу хүргүүлсэн.

Тус газар нь 14 хоног тутам цаг үеийн асуудлаар шуурхай хуралдаж, үүрэг даалгаврын биелэлтийг гарган шийдвэрлэж ажилласан.

#### **4. САНАЛ**

Дотоод аудитын удирдлагын программыг ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан цахим системийн талаар мэдлэг олгох гарын авлага, мэдээллээр хангах, төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах;

Дотоод аудиторын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадын болон салбарын ижил төстэй байгууллагуудын туршлага судлахад дэмжлэг үзүүлэх.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**